



/02

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Г Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дорнод бүсийн эрчим хүчний систем” Төрийн өмчит хувьцаат компанийн 2019-2020 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн Улсын байцаагчийн баримтын шалгалтаар нийт 1,822.7 (нэг тэрбум найман зуун хорин хоёр сая долоон зуун мянган төгрөг) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Дорнод бүсийн эрчим хүчний систем” Төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөсүгэй.

1.1. Компанийн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллах;

1.2. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангатгүй биелүүлж ажилласан гүйцэтгэх удирдлагад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

2. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” Төрийн өмчит хувьцаат компанийн 2019-2020 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г. Отгонбаатарт санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1. Шалгалтын тайландаа дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

3.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактаар олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй байх;

3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг олж авахдаа Төрийн өмчийг бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч ажиллах;

3.4. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж, тендер шалгаруулалтын журмыг зөв хэрэглэж худалдан авах үйл ажиллагааг төлөвлөх;

3.5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин тушаал шийдвэргүй, зардлын нэгдсэн тайлангүй болон санхүүгийн

132001068

\Huraldaanii material\2022 он\2022.01.20 1-r huraldaan.docx

бусад баримтыг дутуу бүрдүүлсэн ажилтан нарт хариуцлага тооцож, зөрчлийг давтан гаргахгүйгээр таслан зогсох;

3.6. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;


3.7. Үнэлгээнд хамрагдаагүй газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, үр дүнг санхүүгийн тайланд тусгах;

3.8. Бараа материалын дансанд бүртгэлтэй, он удаан жил хадгалагдсан, компанийд ашиглах боломжгүй сэлбэг, бусад материалыг үнэ тогтоон худалдан борлуулах, хэрэгцээ шаардлагатай байгууллагад шилжүүлэх, акталж хоёрдогч түүхий эдээр ашиглах ажлыг зохион байгуулж арга хэмжээ авч ажиллах;

3.9. Төслийн нэгжид ашиглаж буй төрийн өмчийн автомашиныг эзэмшлийн дагуу ашиглах;

4. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.



ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА

104

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 01 дугаар сарын 31.....
дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга		Хариуцах эзэн	Дүн /мян.төг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Тендер шалгаруулалт, Худалдан авах ажиллагаа	ХААТөлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл арга хэмжээ	Захирал Г.Отгонбаатар Ерөнхий ня-бо Д.Гэрэлчuluун	750,000.00	“Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Төсвийн хууль, Сангийн сайдын тушалаар батлагдсан “ТБОНӨХБАУХА” ажиллагааг төлөвлөх, тайлагнах тухай журмыг мөрдөж ажиллах
		Тендер шалгаруулалтын арга журмыг буруу хэрэглэсэн худалдан авалт		381,538.00	
		Батлагдсан төсвийг хэтрүүлсэн худалдан авалт		32,643.21	
		ХАА-ны тендерт алдагдалтай ажилласан компани шалгаруулсан.		140,066.30	
		Дүн		1,304,247.51	
2	Үндсэн баримтгүй	Тушаал шийдвэргүй	Захирал Г.Отгонбаатар Ерөнхий ня-бо Д.Гэрэлчuluун	69,223.90	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах
		Хөрөнгө гаргах тушаал болон зардлын нэгдсэн тайлангүй ойн арга хэмжээ		224,208.07	
3	Үргүй зардал	Төслийн нэгжид автомашин худалдан авсан	Захирал Г.Отгонбаатар Ерөнхий ня-бо Д.Гэрэлчuluун	225,000.00	Монгол Улсын Төсвийн хууль, Гүйцэтгэх захирлын контрактын гэрээг мөрдөж ажиллах
		Дүн		518,431.97	
		Нийт дүн		1,822,679.48	